


НББОУС 1 БОЛОН НББОУС 8-Д ОРСОН ӨӨРЧЛӨЛТ “МАТЕРИАЛЛАГ”-ЫН ТОДОРХОЙЛОЛТ

САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН ТОЙМ 2019 ОНЫ 1 САР





Хураангуй

2018 оны 10 дугаар сард НББОУСЗ-өөс СТОУС-ын хүрээнд ‘материаллаг’ байдлын тодорхойлолтыг тодорхой болгох өөрчлөлтийг НББОУС 1 Санхүүгийн Тайлан Бэлтгэх болон НББОУС 8 Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцоолол ба Алдаа стандартуудад өөрчлөлт оруулсан. СТОУС-ын дагуу санхүүгийн тайлан бэлтгэхэд юуг материаллаг гэж үзэх тухай ойлголт маш чухал байдаг тул энэхүү тодорхойлолтын өөрчлөлт нь санхүүгийн тайлан бэлтгэгчдийн тайлантай холбоотой гаргах шийдлүүдэд чухал нөлөө үзүүлж болох юм.

Практикт нягтлан бодох бүртгэлийн бодлогыг ямар түвшинд мөрдөхийг тодорхойлох (үндсэн хөрөнгийг капиталжуулах босго дүн гэх мэт), санхүүгийн тайланг хэрэглэгчдэд хамгийн ач холбогдолтой тодруулга юу болохыг тодорхойлох, санхүүгийн тайланд багтсан мэдээллийг ямар түвшинд нэгтгэхийг тодорхойлох (хүлээгдэж буй зээлийн алдагдалд хамаарах санхүүгийн хөрөнгийн багц гэх мэт) нь түгээмэл материаллаг шийдвэр юм.

Эдгээр өөрчлөлтүүд нь НББОУСЗ-ийн санхүүгийн тайланг хялбарчилж, түүнийг хэрэглэгдэх байдлыг өсгөх зорилготой ‘Тодруулгын Санаачилга’ төслийн нэг хэсэг юм.

Орсон өөрчлөлтийг тоймлон харуулбал:



СТАТУС:

Эцсийн – 2018 оны 10 сард гаргасан

ХУЧИН ТӨГӨЛДӨР ХЭРЭГЖИЖ ЭХЛЭХ ӨДӨР:

2020 оны 1 сарын 1-ний өдөр эсвэл түүнээс хойш. Эрт хэрэгжүүлэхийг зөвшөөрнө.

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН НӨЛӨӨ:

Санхүүгийн тайлан бэлтгэх үед материаллагийн тухай ойлголтыг ашиглахад илүү тодорхой болно.

Хуучин тодорхойлолтыг шинэ тодорхойлолттой харьцуулсан харьцуулалтыг харуулав:

Хуучин тодорхойлолт (НББОУС 1 ба НББОУС 8)	Шинэ тодорхойлолт (зөвхөн НББОУС 1)
Аливаа зүйлсийг дангаар нь эсвэл бусад зүйлсийн хамт орхигдуулснаас эсвэл буруу илэрхийлсний үлмаас санхүүгийн тайланд үндэслэж <u>хэрэглэгчдийн</u> гаргах <u>эдийн засгийн шийдвэрт нөлөөлж</u> байвал түүнийг материаллаг гэж үзнэ.	Хэрэв мэдээллийг орхигдуулах, буруу илэрхийлэх, эсвэл <u>тодорхойгүй болгосноор</u> тодорхой тайлагнагч аж ахуйн нэгжийн талаар санхүүгийн мэдээллээр хангадаг нийтлэг зориулалттай санхүүгийн тайлангийн <u>гол хэрэглэгчдийн</u> тухайн санхүүгийн тайланд үндэслэж гаргах <u>шийдвэрт нөлөөлнө</u> гэж <u>үндэслэлтэйгээр таамаглаж болохоор</u> бол эдгээр мэдээлэл нь материаллаг байна.

Шинэ тодорхойлолтоор уг тодорхойлолтыг ашиглах “босго”-ыг нэмэгдүүлж өгсөн. Өмнөх тодорхойлолтын дагуу хэрэглэгчдэд нөлөөлж байгаа эсэх тухай ойлголтод “болно” гэсэн нэр томъёог ашиглаж, үүнийг олон төрлөөр тайлбарлан ойлгодог байсан. Шинэчлэгдсэн тодорхойлолтоор хэрэглэгчдэд үзүүлэх аливаа нөлөөг үнэлэхийн оронд “үндэслэлтэйгээр таамаглаж болох” гэсэн нэр томъёог ашиглан үндэслэлтэй байдлын элементийг нэмж өмнөх ойлголтыг өөрчилсөн.

Хуучин тодорхойлолтод дурдсан “хэрэглэгч” гэсэн ойлголтыг шинэ тодорхойлолтод “гол хэрэглэгч” болгон нарийвчилснаар тухайн нөхцөл байдалд юу материаллаг байх вэ гэдгийг илүү тодорхой болгосон.


Мөн элемент нь гол хэрэглэгчдэд материаллаг байх эсэхийг тодорхойлоход хамааралтай мэдээллийг тодорхойгүй болгох гэсэн ойлголтыг шинэчилсэн тодорхойлолтоор нэмсэн. Жишээлбэл, балансын дараах томоохон үйл явдлын тодруулгыг санхүүгийн тайланд толилуулах дэс дараалалд томоохон бус зүйлийн тодруулгатай харьцуулахад илүү ач холбогдол өгнө.

Шинэчилсэн тодорхойлолтыг дэмжих дараах нэмэлт заавруудаар мөн хангасан:




Энэхүү зааварт бодлого, толилуулга ба тодруулгын шийдвэрүүд нь СТОУС-ын хүрээнд материаллаг эсэхийг үнэлэх үед хэрэглэгчдэд нэмэлт удирдамж өгнө.

Материаллагийн шинэчилсэн тодорхойлолтын үзүүлж болох практик нөлөөнд дараах зүйлс багтаж болно:



Энэхүү товхимолд шинэчлэгдсэн чухал ойлголтуудыг онцлон харууллаа. Материаллагийн тодорхойлолтын өөрчлөлттэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг НББОУС3-ийн төслийн цахим хуудаснаас [энд](#) дарж авна уу.



This publication has been carefully prepared, but it has been written in general terms and should be seen as broad guidance only. The publication cannot be relied upon to cover specific situations and you should not act, or refrain from acting, upon the information contained therein without obtaining specific professional advice. Please contact your respective BDO Member Firm to discuss these matters in the context of your particular circumstances. Neither BDO IFR Advisory Limited, Brussels Worldwide Services BVBA, BDO International Limited and/or BDO Member Firms, nor their respective partners, employees and/or agents accept or assume any liability or duty of care for any loss arising from any action taken or not taken by anyone in reliance on the information in this publication or for any decision based on it.

Service provision within the international BDO network of independent Member Firms ('the BDO network') in connection with IFRS (comprising International Financial Reporting Standards, International Accounting Standards, and Interpretations developed by the IFRS Interpretations Committee and the former Standing Interpretations Committee), and other documents, as issued by the International Accounting Standards Board, is provided by BDO IFR Advisory Limited, a UK registered company limited by guarantee. Service provision within the BDO network is coordinated by Brussels Worldwide Services BVBA, a limited liability company incorporated in Belgium with its statutory seat in Zaventem.

Each of BDO International Limited (the governing entity of the BDO network), Brussels Worldwide Services BVBA, BDO IFR Advisory Limited and the Member Firms is a separate legal entity and has no liability for another such entity's acts or omissions. Nothing in the arrangements or rules of the BDO network shall constitute or imply an agency relationship or a partnership between BDO International Limited, Brussels Worldwide Services BVBA, BDO IFR Advisory Limited and/or the Member Firms of the BDO network.

BDO is the brand name for the BDO network and for each of the BDO Member Firms.

© 2018 BDO IFR Advisory Limited, a UK registered company limited by guarantee. All rights reserved.

www.bdo.global

www.bdo.mn

